

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн хувь	Тайлбар
			2022	2023			
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ							
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	563,329.8	429,010.0	651636.3	100	
2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	сая төгрөг	7.2	6.0	8.8	100	
3	Төсвийн орлого	сая төгрөг	13,440.1	9,757.6	15838.9	100	
4	Төсвийн зардал	сая төгрөг	28,274.8	26,347.4	39039.5	90	2023.01.01-нээс орон нутгийн нэмэгдэл /40%/ төрийн захиргааны албан хаагчдад олгож эхэлсэн. Мөн 2023.07.01-нээс бүх төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн.
5	Төсвийн тэнцэл	сая төгрөг	14,734.4	16,589.8	23254.6	100	
6	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	84.0	91.5	53.9	50	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 35.8 хувиар буурсан байна. Өмнөх онд Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхэд шилжүүлж төлүүлсэнтэй холбоотой.
7	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төлөлтийн хувь	хувь	53.7	36.4	41	90	Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.6 хувиар буурсан боловч 2023 оны зорилтод түвшингөөс 12.6 хувиар давсан үзүүлэлттэй байна. Өмнөх онуудад хугацаа хэтэрч хуримтлагдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхэд шилжүүлж төлүүлсэнтэй холбоотой.
8	Ажилгүйдлийн түвшин	хувь	6.3	6.0	2.5	100	2023 оны 3-р улирлын байдлаар тооцов.
9	Ажиллах хүчний оролцооны хувь	хувь	65.0	69.9	78.6	100	
10	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	Хувь	78.9	79.2	87.3	100	
11	Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ын нийгмийн даатгалд эзлэх хувь	хувь	52.2	51.2	57	100	
12	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	тоо	1,304.0	1,400.0	1517	100	
13	Хэрэглээний үнийн индекс	индекс	115.8	104.0	106.2	90	ҮСХ-оос гаргасан аргачлалаар хэрэглээний үнийн индексийг 2015 оныг суурь он болгон бодож байсныг 2023 оноос эхлээд 2020 оныг суурь он болгон боддог болсон. Иймд 2023 оныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хэрэглээний үнийн индекс 106.2 буюу 6.2 хувиар өссөн байна.
14	Малын тоо	мянган толгой	3,720.7	3,852.0	3067.6	50	Өмнөх оны мөн үеийнхээс 17.5 хувиар буурсан нь ган зудын нөхцөл байдалтай холбоотойгоор 1.2 сая толгой малыг эдийн засгийн эргэлтэнд оруулсан.
15	Хураан авсан үр тариа	мянган тонн	0.75	1.6	0.7	50	
16	Хураан авсан малын тэжээл бусад	мянган тонн	4.7	18.2	14.9	50	
17	Хураан авсан хүнсний ногоо	мянган тонн	2.7	3.7	1.3	30	
18	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	тоо	830.0	3,000.0	11467	100	ITM MONGOLIA, Аймгийн 100 жилийн ой, болон түүхэн дурсгалт газрууд сурталчилан эмхэтгэл, нугалбарыг тарааж, түншлэлийн гэрээ, хэлэлцээр хийж, тур оператор байгууллагуудтай хамтран ажилласнаар жуулчдын тоо өссөн.
19	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	тоо	1,240.0	1,450.0	1,359	70	

20	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувь	хувь	12.2	28.0	13.6	70	
21	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	49.1	52.0	57.9	100	Аймгийн хэмжээнд цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо 2022 онтой харьцуулахад 8.8%-иар өсч, нарны эх үүсвэрээр өөрийн хэрэглээг хангаж буй иргэд 28.9%-ийг эзэлж байна
Дун						82.86	
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ							
22	Хүн амын дундаж наслалт	Тоо	71.48	70.81	72.8	100	
23	Хүний хөгжлийн индекс	индекс	0.716	0.679	0.72	100	
24	Жендерийн тэгш бус байдлын индекс	индекс	0.259	0.303	0.257	100	
25	Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	405.0	230.0	328	30	
26	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	хувь	50.0	47.4	63.2	100	
27	PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж	М кг/м3	25.0	33.0	19	100	Хэмжилтийн дүнгээс харахад сарын дундаж агууламж 3-43 мкг/м3 хэлбэлзэлтэй жилийн дундаж 19 мкг/м3 байна.
28	PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж	М кг/м3	39.0	35.0	25	100	PM10 тоосонцор 250 удаа хэмжилт хийгдсэн. Хэмжилтийн дүнгээс харахад сарын дундаж агууламж 4-58 мкг/м3 хэлбэлзэлтэй жилийн дундаж 25 мкг/м3 2023 оны дундаж агууламжийг 2 жилийн дундаж агууламжтай харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.
29	Ойгоор бүрхэгдсэн талбайн эзлэх хувь	хувь	6.242	6.078	6.075	30	2023 онд улсын төсвөөр 130 га ойн нөхөн сэргээлтийн ажил, төсөл хөтөлбөрийн хамтарсан санхүүжилтээр 95 га татмын ойжуулалтын ажил, орон нутгийн төсвөөр 50 га ойн нөхөн сэргээлтийн ажил, төслийн санхүүжилтээр 8 га ойн зурвас байгуулах ажил нийт 283 га-д ойн нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн. Ойгоор бүрхэгдсэн талбай 283 га буюу 0.003-иар өссөн.
30	Дахин боловсруулсан хог хаягдлын эзлэх хувь	хувь	0.07	0.02	1.3	100	2017 онд хог хаягдлын тухай хууль шинэчлэгдэж, дахин боловсруулах боломжтой дахивар бүтээгдэхүүнийг эрх бүхий байгууллагууруу шилжүүлнэ гэсний дагуу уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн энгийн болон аюултай хог хаягдлыг дахин боловсруулж байгаатай холбоотой. 2023 онд Баянайраг эксплорэйшн ХХК-ны үйл ажиллагааг зогсоосонтой холбоотой.
31	Хот суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь	хувь	47.0	15.0	15	90	Аймгийн хэмжээнд 2023 онд нийт 39.028 тн хог хаягдал үүссэн
32	100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин	Промиль	0	-	0	100	
33	1,000 амьд төрөлтөд ногдох нялсхын эндэгдлийн түвшин	Промиль	11.9	15.5	14.1	30	2023 онд нялсхын эндэгдлийн түвшин өссөн хэдий ч сүүлийн жилүүдэд эндэгдлийг бууруулах чиглэлээр тодорхой төлөвлөгөө гарган ажилсанаар 2019 оны суурь түвшингөөс 2.0 промил, 2023 оны зорилтот түвшингөөс 1.4 промилээр буурсан байна.
34	10,000 хүн амд вируст гепатитын өвчлөл	тоо	0.1	0.2	0.1	100	
35	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	98.9	99.0	99	100	
36	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	36.3	50.0	41.3	70	
37	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	50.4	56.7	50.6	70	Эрт илрүүлэг үзлэг орон даяар явагдаж байгаа боловч эмч нар артер чихрийн шижин хорт хавдрын эрт илрүүлгийг давхар хийж бүртгэж

							өаина.
38	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	31.0	32.5	26.5	50	
39	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	83.3	86.7	85.8	90	
40	Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин	Хувь	94.6	97.4	92.1	70	
41	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	27.8	25.6	25.8	90	
42	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	тоо	26.2	25.5	25.5	100	
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	509.4	490.0	499.8	90	
44	Оюутан цэрэг сургалтад хамрагдах суралцагчдын тоо	тоо	15.0	15.0	50	100	1500 он бэлдэнээ гэж зорилт тавиад орон нутагт явах цэргээ хасаад, оюутны холбооны удтай уулзалт хийж цэргийн тоог нэмж өгөөч гэсэн хүсэлт өгөөд, 2022 онд тодотголоор тодорхой хэмжээгээр хассан.
45	Төрийн цахим үйлчилгээний тоо	тоо	104	65	464	100	2023 онд 35 байгууллагын 440 үйлчилгээг үзүүлж байсан ба хөгжүүлэлт хийж 2023 оны жилийн эцэст 50 байгууллагын 464 төрийн цахим үйлчилгээг E-Mongolia операторын системээр дамжуулан үзүүлж байна.
Дүн						83.75	
Нийт дүн						83.30	

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг Засгийн газрын 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлгээг хийж эдийн засаг, нийгмийн гол үзүүлэлтийн хүрсэн үр дүн, дутагдал, төлөвлөлтийн уялдаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 6.2, 7.1 дэх заалт хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зарчмын дагуу эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэлж дүгнэв.

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ, НЭГТГЭХ

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох хэлтэс, агентлагуудаас мэдээллийг авч, ҮСХорооны www.1212.mn цахим хуудсанд байрших албан ёсны статистик мэдээ, холбогдох байгууллагуудын мэдээлэлтэй уялдуулан нягталж, нэгтгэн гаргалаа.

ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТИЙН ДҮНГ ҮНЭЛЭХ

Аймгийн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох эдийн засгийн хөгжлийн 21 үзүүлэлт 82.86 хувь, нийгмийн 24 үзүүлэлт 83.75 хувь, нийт дүнгээр **83.3** хувийн гүйцэтгэлтэй байна.



БИЕЛЭЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийн биелэлтийн үр нөлөөг авч үзэхэд нийт 45 шалгуур үзүүлэлтийн 51.1 хувь нь үр дүнтэй, 28.9 хувь нь тодорхой үр дүнд хүрсэн, 20.0 хувь нь эрчимжүүлэх шаардлагатай байна.

Эрчимжүүлэх шаардлагатай үзүүлэлтийн шалтгааныг авч үзвэл:





2023 онд эдийн засгийн үзүүлэлтүүд өмнөх оноос харьцангуй сайжирч байгаа нь дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөллөөс аажмаар гарч сэргэж байгаа нь харагдаж байна. Учир нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагын тоо өмнөх оноос өссөн, ажилгүйдлийн түвшин буурч, ажиллах хүчний оролцооны түвшин нэмэгдсэн зэрэг үзүүлэлтээс харж болохоор байна.

Энэ жилийн тухайд хадлан тэжээл бэлтгэлийн ажлыг үе шаттайгаар зохих түвшинд зохион байгуулсан хэдий ч байгалийн хүчин зүйлээс шалтгаалан малын тоо, хадлан, тэжээл бэлтгэлт, ургац хураалт зэрэг үзүүлэлтүүд буурсан байна.

Эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

2023 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ статистик мэдээгээр 2024 оны 6 сард гарах учир 2022 оны дотоодын нийт бүтээгдэхүүний тоо, хэмжээгээр үзүүлэлтийг тооцсон болно.

Жижиг дунд үйлдвэрийн зээлийн эргэн төлөлтийн хувь өмнөх оноос буурсан нь өмнөх жилүүдэд Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангийн хугацаа хэтэрсэн зээлүүдийг шүүхэд шилжүүлж төлүүлсэн, мөн график төлөлтөндөө орж байгаатай холбоотой байна.

Хэрэглээний үнийн индексийг 2022 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 115,8 буюу 15,8 хувиар өссөн бол 2023 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 106,2 хувь буюу 6,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Үндэсний Статистикийн хорооны хэрэглээний үнийн индекс тооцоолох аргачлал дээр суурь оноо 2023 оноос өмнөхийг 2015 оноор, 2023 оноос хойш суурь оныг 2020 оноор тооцоолдог болсонтой холбоотой юм.

Малын тоо 2020 оноос хойш 3 жил дараалан буурч байгаа нь малчид газрын гарц муу, өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байсан тул зах зээлийн эргэлтэнд оруулж борлуулалт их хийсэн байна.

Мөн 2023 онд малын тэжээл тариалалт нэмэгдсэн боловч үр тариа, хүнсний ногооны ургац өмнөх оноос буурсан нь байгаль цаг ууртай холбоотойгоор газрын гарц муу, хур бороо муу байснаас шалтгаалсан байна.

Нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хүрээнд:

PM2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж 2022 онд 25 байсан бол 2023 онд 19, PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж 2022 онд 39.0 байсан бол 2023 онд 25 болж буурсан байна. Энэ нь агаар бохирдуулах эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлээр



усан халаалттай 15-100 кВт хүчин чадалтай 1 зуух цахилгаан, 1 зуух төвлөрсөн халаалтанд холбогдсон, 2 зуух нэгдэж, 4 зуухны үйл ажиллагаа зогссон, Их-Уул сумын 9 зуух, Отгон сумын 8 зуух 101-4200 кВт төвлөрсөн халаалтанд холбогдсон зэргээс шалтгаалсан байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин 2022 онтой харьцуулахад 2,2 промилээр өссөн боловч 2019 оны суурь түвшингөөс 2,0 промил, 2023 оны зорилтот түвшингөөс 1,4 промилээр буурсан үзүүлэлттэй байна.

Энэ нь Хүүхдийн нарийн мэргэжлийн эмч нарыг түлхүү бэлтгэх, сумдын эрүүл мэндийн төвийг хүүхдийн эмчтэй болгох зорилт тавин ажиллаж 10 гаруй сумыг хүүхдийн эмчтэй болгож, хүүхдийн яаралтай тусламжийн нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалтыг бүрэн хийсэн. Мөн Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт сурфактант эмчилгээг нэтрүүлсэн зэрэг шат дараалсан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн нь нялхсын эндэгдэл буурахад гол нөлөө үзүүлж байна.

Артерийн даралтын ихсэх өвчний эрт илрүүлэг, чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралт 2022 оноос өмнөх жилүүдэд зорилтот бүлэгт чиглэн хамруулж хамрагдалтын хувь өндөр байдаг байсан. 2022 оноос Эрүүл мэндийн сайдын тушаалаар 18 наснаас дээш насны иргэдийг хамруулдаг болсонтой холбоотой хамрагдалтын хувь бага харагдаж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг тооцоо судалгаа, үндэслэлтэйгээр төлөвлөж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах талаар хэлтэс, агентлагуудад зөвлөмж хүргүүлээ.

Цаг хугацааны хувьд тухайн оны статистик мэдээгээр дараа оны 1, 2 дугаар улиралд гардаг мэдээлэл байдаг тул хяналт-шинжилгээ, үнэлгээг өмнөх оны үзүүлэлтээр хэрэгжилтийг тооцож ажилласан.

Завхан аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт өмнөх оноос буурсан байгаа нь цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт удаашралтай, инфляцын түвшин өссөн, ган зуд, байгалийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөө зэрэгтэй холбоотой юм.